



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аудитын сэдэв: “Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргах”

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв.

**АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГЫГ 327.8 САЯ ТӨГРӨГӨӨР
НЭМЭГДҮҮЛЖ, ЗАРЛАГЫГ 478.8 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ
БОЛОМЖ БАЙНА.**

Аудитын тайланг хүргүүлсэн: Дархан-Уул аймгийн ИТХ, Засаг дарга

ДАРХАН-УУЛ АЙМАГ

2024 оны 11 дүгээр сар

Аудитын зорилго, зорилтууд:

Дархан-Уул аймгийн ТЕЗ-аас аймгийн ИТХ-д өргөн мэдүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн төслийг арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэйгөөр боловсруулсан эсэхэд аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлогыг хууль, журамд нийцүүлэн, нөөц боломжийг бүрэн ашиглаж төлөвлөсөн эсэх
- Орон нутгийн төсвийн зарлагыг хууль, журамд нийцүүлэн, арвилан хэмнэлт, үр ашигтайгаар төлөвлөсөн эсэх

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар аймгийн 2024 оны төсөв, төсвийн тодотгол, хүлээгдэж байгаа гүйцэтгэл, аймгийн Засаг даргаас Сангийн яаманд хүргүүлсэн 2025 оны жилийн төсвийн төсөл, Сангийн Яамнаас хянаж ирүүлсэн тооцоо, холбогдох мэдээлэл, аймгийн ЗДТГ-ын СТСХ болон ХБТХОХ, БОГ, Татварын хэлтэс, сумдын татварын байцаагч болон төсвийн орлого бүрдүүлдэг зарим байгууллагаас ирүүлсэн судалгаа, мэдээлэл, орлого, зардал, төсөвтэй холбоотой тайлан, мэдээ, судалгаа, өмнөх онуудын аудитын тайланг хамруулав.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГЫГ 327.8 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ БАЙНА

1.1. Төсвийн суурь орлогын саналыг хууль, журмын дагуу холбогдох байгууллагын санал, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулжээ.

Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам", орон нутгийн 2025 оны төсвийн төсөл бэлтгэх удирдамжийг үндэслэн боловсруулсан байна.

"Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх" аудитаар өгсөн "Төсвийн суурь орлогын саналыг боловсруулахдаа цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварыг тухайн онд холбогдон гарсан хууль, тогтоомжтой нийцүүлэн, эх үүсвэрийг бодитой төлөвлөх" зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

1.2 Аймгийн төсвийн нийт орлогыг 327.8 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр сумдад олгох санхүүгийн дэмжлэг буурах, сумдаас аймагт төвлөрүүлэх шилжүүлэг нэмэгдэх боломж байна

Орон нутгийн 2025 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах татварын ногдол, өр төлбөрийг барагдуулах чиглэл, өмнөх оны татварын өрийн үлдэгдэлд үндэслэн үл хөдлөх хөрөнгийн албан татварын өрийг 100.0 сая төгрөгөөр, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өрийг 70.0 сая төгрөгөөр, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн өрийг 50.0 сая төгрөгөөр тус тус бууруулж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломж байна. Цаашид орлогын нэр төрөл бүрээр татварын өрийн судалгааг гаргаж төсвийн орлогын төсвийн төсөлд тусгаж байх шаардлагатай байна.

Иймээс аймгийн төсвийн нийт орлогыг 327.8 сая төгрөгөөр нэмэгдүүлснээр аймгийн төсвөөс сумдад олгох санхүүгийн дэмжлэг буурах, сумдаас аймгийн төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТӨСӨЛД ТУСГАГДСАН ЗАРДЛЫГ 478.8 САЯ ТӨГРӨГӨӨР БУУРУУЛАХ БОЛОМЖ БАЙНА

2.1. Урсгал зардлын ангилалд хамаарах зардлын дүнг 478.8 сая төгрөгөөр бууруулах боломжтой байна.

Аудитаар төсвийн урсгал зардлыг байгууллага тус бүрээр судлан үзэхэд Төсвийн тухай хууль болон бусад хууль эрхийн актуудтай нийцээгүй дараах 478.8 сая төгрөгийн зардлыг хасах саналтай байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын төсвийн төслөөс 101.2 сая төгрөгийг,
- Аймгийн ИТХ-ын төсвийн төслөөс 119.1 сая төгрөгийг,
- Ахмадын хөгжлийн төвийн төсвийн төслөөс 54.2 нийт сая төгрөгийг,
- Худалдан авах ажиллагааны газрын төсвийн төслөөс 143.7 сая төгрөгийг,
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны төсвийн төслөөс 10.9 сая төгрөгийг,
- Дархан сумын ИТХ-ын төсвийн төслөөс 7.6 сая төгрөгийг,
- “Дархан үйлдвэрлэл технологийн парк” ОНӨААТҮГ нь үйл ажиллагаа явуулаагүй тул 42.1 сая төгрөгийн цалин хөлс, НДШ-ийн зардлыг тус тус хасах саналтай байна.

2.2 Аймгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөр, жилийн төлөвлөгөөнд тусгагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр 22,281.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 28 төсөл, арга хэмжээг 16,005.6 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төсөвлөжээ.

Хүснэгт 3 Төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжих төсөл, арга хэмжээ

№	Төсөл, арга хэмжээний нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	2025 онд санхүүжих дүн
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар	11	5,445.7	5,266.2
2	Замын сангийн хөрөнгөөр	3	5,977.6	2,340.0
3	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр	14	10,858.0	8,399.4
Нийт дүн		28	22,281.30	16,005.60

Эх сурвалж: Орон нутгийн хөрөнгө оруулалтын 2025 оны төсвийн төсөл

Дээрх шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, 2025 онд хөгжүүлэх хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.

Аймгийн төсвийн нийт орлогыг 327.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, зарлагыг 478.8 сая төгрөгөөр бууруулах боломж байна гэсэн дүгнэлтийг хүргүүлэв.